



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 7 сарын 21 өдөр

Дугаар 80

Эрдэнэт

Ээлжит хуралдаан
зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит II хуралдааныг 2016 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Эрдэнэт хотод хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.Аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн хугацааны бодлогын үндсэн чиглэл батлах тухай.

2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай.

3.Аймгийн ИТХ-ын хороо байгуулах, бүрэлдэхүүнийг сонгох тухай.

4.Аймгийн 2015 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит II хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

Гурав.Аймгийн ИТХ-ын Ээлжит II хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.



ДАРГА

П.ПҮРЭВЛХАГВА

00109237